

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ**

Жигмэдийн Нэргүй

**ШАХМАЛ ШҮДЭЛБЭРИЙН ЗОХИОМЖИЙГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЭМНЭЛЗҮЙН АСУУДАЛ**

Е 723800 нүүр ам судлал

Анагаах Ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот
2009 он

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ**

© гар бичмэлийн эрхтэй

Жигмэдийн Нэргүй

**ШАХМАЛ ШҮДЭЛБЭРИЙН ЗОХИОМЖИЙГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЭМНЭЛЗҮЙН АСУУДАЛ**

Е 723800 нүүр ам судлал

Анагаах Ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот
2009 он

Магистрын судалгааны ажлыг ЭМШУИС (Захирал, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Ц.Лхагвасүрэн), Нүүр Ам Судлалын Сургууль (Захирал, Анагаах ухааны доктор дэд профессор Б.Амарсайхан), Нүүр Амны Согог Гажиг Заслын тэнхим (Эрхлэгч, Анагаах ухааны доктор, профессор Н.Пүрэвжав), Энэрэл Дент эмнэлэг (Захирал, Анагаах ухааны магистр М.Ичинхорлоо)-т хийж гүйцэтгэв.

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч

Д.Одончимэг. Анагаах ухааны доктор (Ph.D)

Эрдэм шинжилгээний зөвлөх

Н.Пүрэвжав Анагаах ухааны доктор профессор

ХУРААНГУЙ

ШАХМАЛ ШҮДЭЛБЭРИЙН ЗОХИОМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЭМНЭЛЗҮЙН АСУУДАЛ

Судалгааны ажлын зорилго:

Шахмал шүдэлбэрийг боловсронгуй болгон физиологийн зажлах үр ашгийг тооцох

Аргачлал: Тус судалгааг эмнэлзүйн судалгааны туршилтын аргыг ашиглан Энэрэл-Дент эмнэлэгт 2003-2005 онд авагддаг шахмал буйлтай хуванцар болон ган даравчит матмал дэгээтэй шүдэлбэр хийлгэсэн нийт 1481 үйлчлүүлэгчдээс ган даравчит матмал дэгээтэй шүдэлбэр хийлгэсэн 60 үйлчлүүлэгчид шаардлагатай гэсэн энэ шүдэлбэртэй холбоотой хийц, түүний таарамж, сэтгэл ханамжийн мэдээ, мэдээллийг нийгмийн судалгааны тоон аргаар асуумж боловсруулан явуулав.

Үр дүн:

Судалгаанд хамрагдсан нийт авагддаг шүдэлбэр хийлгэсэн үйлчлүүлэгчдийн ган даравчит матмал дэгээтэй шүдэлбэр хийлгэсэн тоо 2003 онд 56%, 2004 онд 82.1%, 2005 онд 93% болон тус тус өсч нийт 75.8% хийгдсэн бөгөөд энэ шүдэлбэрийг зүүж байгаа буюу таарамжтай гэсэн 78%, зүүгээгүй буюу таарамжгүй гэсэн 22% болсон байна. Ган даравчит матмал дэгээтэй шүдэлбэрийн дэгээ нугалах аргачлал нь энгийн бөгөөд цутгамал буйлтай шүдэлбэртэй төстэй хийгдэж байна.

Ган даравчит матмал дэгээтэй шүдэлбэрийн зажлах үйлийн сорилийг харахад зажлах хугацаа 1.92 ± 0.13 сек, зажлаад үлдсэн идээний жин (грамм) 1.89 ± 0.1 зажлах үйлийн алдагдал 36.9 ± 1.44 байна. ($p < 0.001$)

Дүгнэлт: Энэхүү судалгаагаар жил бүр ган даравчит матмал дэгээтэй шүдэлбэрийн хийлгэсэн байдлыг харахад нэмэгдэж байгаа нь өвчөний физиологийн үйл, гоо сайхан тодорхой хэмжээгээр шахмал буйлтай хуванцар шүдэлбэрээс илүү сэргэж бйгааг харуулж байна.

ABSTRACT

DEVELOPING DESIGN OF DENTURE AND TREATMENT ISSUES

BACKGROUND: Public and state dental clinics have been making the denture that is taking on the small, medium, large defect in our country. 85,96 +1,7 percent of the most treatment of galvanizing defects of all teeth's rows are provisional denture. The high technology development countries are using those type of provisional denture for the diagnosing, recovering . Nowadays high technology is developing extremely quicken for treatment of defects dental field there is a new technology is using to make like a human teeth that is not depends of defects size of teeth. Those type of technology is using in our country now.

Provisional denture has been made for people to be needs accuracy technology, high costly equipment, estimated price so our countries most consumers unable to make it and their economics is not enough. Therefore now we are studying to use the denture with wrought wire clasp and rest. That is cheaper than that provisional denture and suitable for economic market, useful for medicine and practical importance which is main basis for studying.

OBJECTIVE: The main purpose of this study is to develop of provisional denture.

MATERIALS AND METHODS: This study has been used to study of experimental method of medicine. "Enerel" dental clinic served 1481 people whom they were made denture between 2003 and 2005. From those people were made denture with wrought clasp for 60 people. By experimental study jawing activity test has been used by E.S Rubonov method there were 60 people who were made denture with wrought wire clasp and rest such as full row of teeth 5 , all totally there were 65 people.

This wrap methods of the denture with wrought wire clasp and rest has been made at the "Enerel" dental clinic's laboratory, (appendexl)

RESULTS: Denture with wrought clasp needs was increasing gradually until 56 percents in 2003, 82.1 percents in 2004, 93 percents in 2005. A large number of denture with wrought clasp was made 32.4 percent of maxilla, 47.1 percent was mandible but this denture were used and suited for people 78 percent, 22 percent of people who made those type of denture did not and uncomfortable for them. Denture with wrought clasp jawing activity was 1.92 ± 0.13 seconds and jawed things weight was 1.89 ± 0.1 , lost of jawing activity was 2.69 ± 1.44 ($p < 0.001$).

CONCLUSION: Method of denture with wrought clasp is more simple and nearly minted removable denture.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ

УДИРТГАЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ

1.1 Авагддаг шүдэлбэрийн хэрэгцээ

1.2 Шүдэлбэрийн дэгээний тогтолцоо

1.2.1 Дэгээ, дэгээний систем

1.2.2 Дэгээг зохиомжлох

1.2.3 Дэгээг бэхлэх тулгуур шүдийг сонгож авах

1.2.4 Дэгээг боловсронгуй болгож зохиомжилж буй хандлага

1.3 Шүдэлбэрийн зажлах үр ашгийг тооцох.....

1.3.1 Зажлалтын үр ашгийг тооцох статистик аргууд.....

1.3.1 Зажлах үйлийн сорил

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

2.1 Судалгааны арга

2.2 Түүврийн хүрээ ба нэгж

2.3 Матмал дэгээ нугалах аргачлал.....

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

3.1 Авагддаг шүдэлбэрийн хэрэгцээг тодорхойлсон дүн.....

3.2 Зажлах үр ашгийг тооцсон дүн

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХЭЛЦЭМЖ

ДҮГНЭЛТ

НОМ ЗҮЙ

ABSTRACT.....

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ

Манай орны улсын болон хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд шүдний эгнээний бага, дунд, их хэмжээний согогуудыг ихэвчлэн авагддаг шахмал буйлтай хуванцар шүдэлбэрээр сэргээж байна. Нийт шүдний эгнээний согогыг сэргээж байгаа эмчилгээний дийлэнхи нь буюу 85,9 % шахмал буйлтай хуванцар шүдэлбэр байсан болно.¹ Техник технологи өндөр хөгжсөн дэлхийн хөгжилтэй ихэнхи орнуудад шахмал буйлтай хуванцар шүдэлбэрийг (шбхш) одоо түр зориулалтаар оношлогоо, эмчилгээ нөхөн сэргээх үед хэрэглэх болжээ. ² Энэ шбхш нь зажлалтын даралтыг шууд салст болон түүшин сэртэнд дамжуулснаар эрүү, хоншоорын ялангуяа эрүүний ясны шимэгдэлтийг хурдасгадаг байна. Харин металл дэгээ, даравчтай шүдэлбэр нь зажлалтын даралтыг шүд, түүний тулгуур эд болон түүшин сэртэнд нэгэн жигд дамжуулдаг учраас эрүү, хоншоорын хатингаршил харьцангуй багасдаг болно.

ДЭМБ-аас эрүүл мэндэд нөлөөлж байгаа голлох өвчлөлийг бүхэлд нь бага зардлаар урьдчилан сэргийлэх, эмчлэх бүрэн боломжтой ч эдийн засгийн өндөр үр дүнтэй тэдгээр арга, технологийг хөрөнгө мөнгөний гачааллаас болж хөгжиж байгаа улс орнууд төдийлөн хэрэгжүүлж чадахгүй байгааг дурдсан байна. Дэвшүүлсэн гол асуудал нь хөгжиж байгаа орнуудад хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар хийх алхам, арга хэмжээ бүр ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх ач холбогдолтой байх гэжээ.³

Өнөө үед шүдний согогыг зохиомж, техник, материал, өртгөөрөө ялгаатай хэд хэдэн төрлийн авагддаг шүдэлбэрээр сэргээж байна. Авагддаг шүдний тулгуурлалт, тогтвор, барилт, холбиролтыг хэр зэрэг боловсронгуй болгосноор өөрөөр хэлбэл хэр нарийн зохиомжтой дарааллаар нь шбхш, ган даравчит матмал дэгээтэй шүдэлбэр (гдмдш), цутгамал буйлтай шүдэлбэр (цбш) хийгдэж байна. Шүдний согог заслын салбарт дэвшилтэт технологи асар хурдацтай хөгжиж байгаа орчин үед шүдний эгнээний согогын хэмжээнээс хамааралгүй эрүү, хоншоорын ясанд суулгадаг технологи (имплант) нэвтэрсээр байна. Манай орны тухайд ч шинэ дэвшилтэт технологиуд нэвтэрч байгаа билээ. Нарийн техник технологи, үнэтэй тоног төхөөрөмж шаарддаг, өртөг өндөртэй хийгддэг шүдэлбэрийг манай улсын согог заслын клиникт үйлчлүүлэгсдийн олонхи нь хийлгэх боломжгүй байна. Иймд бидний судалж байгаа ган даравчит матмал дэгээтэй хуванцар шүдэлбэр нь үйл ажиллагааны хувьд, өртөгийн хувьд өнөөгийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхүйц харьцангуй хямд, хийхэд хялбар, эмнэлзүйн практикт үр ашигтай зэрэг нь судалгаа хийх үндэслэл болсон юм.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Шахмал шүдэлбэрийг боловсронгуй болгон физиологийн зажлах үр ашгийг тооцох

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛТ

1. Авагддаг шахмал шүдэлбэрийн хийсэн хэрэглээний өсөлтийг судлах
2. Ган даравчит матмал дэгээ нугалсан шахмал шүдэлбэрийг нэвтрүүлэх
3. Гдмд шүдэлбэрийн зажлах үр ашгийг тооцох

СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ

Ган даравчит матмал дэгээтэй шүдэлбэрийг судалж байгаа анхны судалгаа

ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ

Бидний судалж байгаа ган даравчит матмал дэгээтэй хуванцар шүдэлбэрийн дэгээг параллелометр ашиглан Аккерийн 1-р дэгээний ангиллаар Кеннедийн бүх ангиллалын согогыг бүрэн сэргээх боломжтойгоор ач холбогдолтой.

Судалгааны ажлын багтаамж

Энэхүү бүтээл нь судалгааны ажлын үндэслэл, зорилго, зорилт, шинэлэг тал, практик ач холбогдол, судалгааны материал арга зүй, судалгааны үр дүн, хэлцэмж, дүгнэлт, гэсэн 4 үндсэн бүлэг, зураг 6 , хүснэгт 4-өөс бүрдэнэ.

Хамгаалахаар дэвшүүлж буй асуудал

“Шахмал буйлтай шүдэлбэрийн зохиомжийг боловсронгуй болгох эмнэлзүйн асуудал” -д шахмал буйлтай хуванцар шүдэлбэрт матаж нугалсан ган даравчтай дэгээг зохиомжилсноор шүдэлбэрийн хэрэгцээ болон зажлах үйлд хэрхэн нөлөөлж байгааг судлахад оршино.

Судалгааны ажлын хэлэлцүүлсэн байдал

1. ЭМШУИС-ийн НАСС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар ажлын сэдэв, арга аргачлалаа батлуулсан. Протокол № 2006.09.18.
2. ЭМШУИС-ийн НАСС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар ажлын явц, үр дүнг хэлэлцсэн. Протокол №6, 2009.01.27
3. ЭМШУИС-ийн НАСС-ийн НАСГЗ-ын тэнхимийн хурлаар ажлын явц үр дүнг хэлэлцсэн протокол №9, 2009.05 сар
4. ЭМШУИС-ийн НАСС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар ажлын явц үр дүнг хэлэлцсэн протокол № , 2009.06.03

Судалгааны ажлын хүрээнд тавьсан илтгэлүүд

1. Ач Анагаах Ухааны Сургуулийн Эрдмийн Чуулган (2007) УБ хот
2. Нүүр Амны Мэргэжилтэнүүдийн Эрдмийн Чуулган. УБ хот. 2008.10.19
3. ЭМШУИС-ийн НАСС-ийн “ Эрдмийн чуулган 2009” УБ хот. 2009.04.02

НОМ ЗҮЙ

1. Батаа.Д.Шүдний эгнээний согогын төлөв, ангилал, эмнэлзүй, эмчилгээний асуудлууд. А/У-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт хураангуй бүтээл.1996. 15
2. Weintraub GS. Provisional removable partial and complete protheses. North America, Philadelhia. 1989. <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
3. Мөнх-Эрдэнэ.Л 2009 Эрүүл мэндийн салбарын санхүүжилт ба тулгамдаж байгаа асуудлууд.УБ. 2009. 4-5
4. Division of Epidemiology and Oral Disease Prevention, National Institute of Dental Research , National Institutes of Health. Denture use and the tehcnical quality of dental protheses among person 18-74 years of age. USA. (1988-1991). 1996.Feb 75 Spes №714-25. from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
5. Sato T, Ohno S, OkadaD, Kawawa A, Akiba H, WatanabeY, Endo K, Mayanagi A, Miura H, Hasegawa S. Statisical analysis of fabrication of fixed and removable partial dentures. Japan. Tokyo.(1986) [Pubmed-inexed for Medline]1999.09
6. Owall J. Removable partial denture production in German. 1995 Sep;26(9)621-7 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
7. Owall J. Removable partial denture production in Sotland. 1996 Dec;27(12):809-15 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
8. Rummet S.K, Wilson M.A, Marker V.A, Nunn M.E, Quality of removable partial denture worn by the adult U.S. population. USA, Texas. 2002Jul;88(1):37-43 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
9. Janus C, Hunt RJ. Rural and Urban differences in prosthodontic care provided by Virginia general dentists. USA, Virginia. 2008 Jul-Aug;56(5):438-42 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
10. Пүрэвжав. Н. Амарсайхан.Б.1996.Нүүр амны согог, гажиг засал.УБ. "Эрхэс" хэвлэх үйлдвэр. (2) 59-74, (4)152-165
11. Dr. Charles G.Eller. Pierre Faucherd Academy. Franch. Paris. 2009.
12. Jonson D.L Retention for removable partial denture. USA. Oklahoma City. 19921992 Sep;1(1):11-7 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
13. Benjakul P, Chevnarram C, Onqthiemsak C. Flexibility and hardness of dental stainless steel wrought wires used in Thailand. 2001 Mar;43(1):15-9.) [Pubmed-inexed for Medline]
14. Евдокимова А.И.1974. *Руководство по Ортопедический Стоматологии*. ОХУ. Москва, Издательство «Медицина».181-195

15. Russell J, Stratton / Frank J, Wiebelt 1988. *An Atlas removable Partial Denture Design*. Edwards Brothers Inc., Ann Arbor, MI Printed in U.S.A.1(2) 11-23
16. Daewoon Joo. 2003.*Removable partial dentures*. Edited by Daewoon Joo D.D.S. 11
17. Sato Y, Shindoi N, Koretake K, Hosokawa R The effect of occlusal rest size and shape on yield strength. Japan. Tokyo, 2003
18. Жулёв Н. 1998. *Несъёмные протезы*. "Нижегородский Печатник". Новогород. 25-28
19. Davenport J.C. Basker R.M.Heath J.R. 1988. *A Colour Atlas Removable partial denture*. Published by W.S.Cowell Ltd, Ipswich, England. 2(1) 40-45
20. Wu L, Ai HJ, Lv PJ, Wang YP. Design of geometric models of the removable partial denture framework. China. Shenyang. 2006 Apr;15(2):213-7 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
21. Shirasu K. Influence of residual stress in wrought wire clasps on bending properties. Japan. 2008 Mar;75(1):6-12 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
22. Vallittu PK. Fatigue resistance and stress of wrought-steel wire clasps. Finland. 1996 Sep;5(3):186-92 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
23. Brown R.B. 1965. Dental Technican prosthetic. Published by Bureau of Naval Personnel. 5(2)
24. Hazel O. Torres.C.D.A., R.D.A., M.A. Ann Ehrlich. C.D.A., M.A. 1985. *Modern Dental Assisting*. Made in The United States of America.27(1) 787-796
25. Zhang F, Zhu M, She W. A study on the cariogenic bacteria of plaque on abutment teeth of casting and wrought wire vlassp removable partial denture. China. Shanghai. 1999 Jan;34(1):37-9 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
26. Sallen NH, Fuiki K, Garrett NR, Ohshima T. Objective and subjective hardness of test item used for evaluating food mixing ability. Japan. Tokyo. 2007 Mar;34(3):174-83 from <http://www.ncbi.nlm.gov/pubmed/>
27. Пүрэвжав. Н. Функционально эстетически основы ортопедического лечение при полной утраты зубов. УБ. 2005.А/У-ны нэг сэдэвт зэрэг горилсон бүтээл. 23-24